

ХАЙКУ ШҮЛГИЙН МОНГОЛ ОРЧУУЛГАД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

С.Долгор⁶³

Д.Будсүрэн⁶⁴

Abstract: Poetry expresses things of nature and feelings in human life as rhythmic linguistic form. The message is conveyed not only by the superficial meaning of words, but also by aesthetic and evocative property of words. Subtle emotions or beauty of nature scenery can be expressed in long writings, but they can also be expressed as poems. Even if poems are short, however, it can record the atmosphere of the place by the profoundness of words. In my report it will be shown that I did some observation to the translation. It tends that the poetry translation is directly connected with the interpreter's experience of recognizing things and his/her own feature of receiving and knowing things and datas.

Түлхүүр үг: Хайку, киго, кирэжи, харьцуулалт, сэтгэлгээний онцлог

Удиртгал

Ертөнцийн юм үзэгдэл, хөдөлгөөний санамсаргүй нэрлэлт болон олон хэлнээ байх түгээмэл чанартай үг хэллэг аль ч улс түмний хэлэнд бий ч өөр өөрийн үндэсний сэтгэлгээний өвөрмөц онцлогийг хадгалсан хэлний нэгжүүд тухайн хэлний нандин өв болон оршсоор үеэс үед дамжин хадгалагдаж хөгждөг. Шүлгийг цогцлон бүтээхэд эгшиг дуун бол аль ч ард түмний хэл яриаг урнаар өгүүлэхэд гол шалгуур болдог аж .

Уран сайхны, тэр дундаас шүлэглэсэн яруу найргийн орчуулга хийх гэдэг нь маш их бэрх хөдөлмөр. Үндэстний сэтгэлгээ, аж байдал, соёлын өвөрмөц байдал, хэлний байгуулалт, бүтэц, түүнээс үүдсэн үндэстэн бүрийн шүлгийн давтагдашгүй өвөрмөц арга зүй, юмс үзэгдлийг томъёолсон үгсийн өөр өөр байдал гэх мэт олон зүйл үүнд шууд нөлөөлдөг билээ. Яруу найргийн орчуулга нь аливаа улс үндэстний соёл, урлагийг баяжуулан хөгжүүлэхэд үлэмж нөлөө үзүүлсээр ирсэн юм. Хүн төрөлхтний түүхэнд улс үндэстнүүд орчуулгын бүтээлээр холбогдож байсан.

Манай орны хувьд эрт дээр үеэс харь хэлнээс зохиол бүтээл, судар номыг орчуулан монгол хэлнээ буулгасаар ирсэн. Улс орны хөгжил, соёлт нийгмийн жам ёсоор ХХ зуунаас дэлхийн сор бүтээлүүдийг монгол хэлнээ орчуулж уншигч олондоо хүргэсээр байна.

Үндэсний сэтгэлзүйн онцлог, тэрхүү үндэстэн ястны сэтгэл бодол, зан ааль хэлээр дамжин илэрдэг. Хэлнээ тухайн ард түмний аж төрөл, ахуй үйлийн

⁶³ Доктор /Ph.D/, МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим

⁶⁴ МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази судлалын тэнхимийн докторант

туршлага хадгалагдаж байдаг учраас хэл нь ард түмний соёлыг үеэс үед дамжуулдаг хэрэглүүр мөн. (Равдан Э, 2005:191-193)

Түгээмэл хэлзүйн онолын үүднээс өгүүлэгч хүн хүмүүний нийт хэлний түгээмэл зарчмууд, тухайн тодорхой хэлний онцлогийг тусгасан хувьсах хэмжихүүний цогц бүрдлийн мэдлэгтэй байдаг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хэл эзэмших гэдэг нь сурах тодорхой хэлэндээ олон хэлний нийтлэг зарчмуудыг хэрэгжүүлэх, нөгөөтэйгүүр уг тодорхой хэлэнд хадагдсан олон хэмжихүүнийг мэдэх гэсэнтэй агаар нэг юм. Уг онолын ерөнхий үзэл баримтлал нь тэр бүр хялбар нарийвчлан тогтоох боломжгүй хүмүүний уураг тархи, танихуйн үйл, түүний олон ухагдуунтай холбоотой. Хэдий тийм ч түгээмэл хэлзүйн онолыг хэлзүйн, хүмүүний ой ухаан, хэлийг нэгтгэн зангидах шинжлэх ухааны нарийн үндэслэл бүхий сав ухаан хэмээн үзвэл зохино. (Равдан Э, 2013:25)

Иймд хэл тус бүрийн бүтцийн өвөрмөц онцлогоос шалтгаалж олон улс үндэстний шүлэглэх ёс, шүлгийн тогтолцоо өөр өөр юм. Шүлгийн тогтолцоо бол эгшиг гийгүүлэгч авиа, тэдгээрийн шинж, урт богино, өргөлт, үе зэрэг тухайн хэлний авианы бодитой онцлогоос шалтгаалан олон янз байх бөгөөд энэ бүхэн бол шүлэг судлалын гол судлагдахуун мөн.

Б.Ринчен - Шүлэг гэдэг зохиол бол бас үг найруулга нь жирийн үргэлжилсэн үгийн зохиолоос өөр тул, монгол уншигч олныхоо өмнө соёлын хариуцлага хүлээсэн шударга журамт орчуулагч хүн орчин дэлхий нийтийн уран орчуулгын арга хэрэглэх үүрэгтэйгээ агшин зуурч үл умартах аваас биеийн алжаахыг үл бодон цаг хүчин үлэмжхэн орохыг үл хэмнэн, гагцхүү сайхан зохиолыг монгол болгохдоо зэрэмдэглэхгүйг нэнд хичээ ... (Ринчен Б, 1991:144)

Шүлэглэл зохиолыг монгол болгохдоо, баян элбэг үгтэй зохиолыг монгол болгохдоо маш баян монгол хэлнийхээ үгсийн сангийн эрдэнээс цаад зохиолын сайхан үгтэй чадал санаа эн чацуу үг хэрэглэхээс гадна бас уг зохиолч нь цаад хэлнийхээ үгийн сангаас сонгон хэрэглэсэн үг нь судрын хэлний үг байвал монгол судрын хэлнээс түүнтэй дүйх сайхан үг сонгон олж, номын хэлнээс хэрэглэсэн үг байвал, монгол номын хэлний зохих үг шигшин шилэн сонгож хэрэглээд, бичгийн хэлний үг хэрэглэсэн байвал, монгол бичгийн хэлний үг хэрэглэж, хар үг хэрэглэсэн газар, мөн түүнтэй амт санаа дүйх хар үг тэнсэн олж хэрэглээд, эх зохиолын хуучин үгий нь монгол хэлнийхээ хуучин үгээр тааруулаад, уншигчийнхаа үгний мэдлэгий нь агуу болгохын үүднээс тайлбар зүүлт зүүх газар нь зүүн тайлбарлаж, оюуны нь амыг нээж өгөх хэрэгтэй байна. (Монголын уран зохиолын дээжис. Билгийн толь – 1. Ринчен, 1998:42)

Гадаад утга зохиолын шилдэг сайн бүтээлүүд өөр орны утга зохиолын санд нэвтрэн орж ямар нэгэн хэмжээгээр утга зохиолын салшгүй хэсэг болдог. Энэхүү нэвтрэх зам нь орчуулга юм. (Долгор С., *Японы уран зохиолын Монгол хэлнээ орчуулсан тойм*, “Японы утга зохиолын симпозиум”, 2004 :25)

Орчуулга хэлний бүтээлч үйл ажиллагааны онцгой төрөл зүйл мөн бөгөөд хэл шинжлэгч, угсаатны зүйч сэтгэл судлаач утга зохиол судлагчдын анхаарал татдаг олон талт ажил юм. Хэл шинжлэгчдийн хувьд орчуулга нь ерөнхий болон

харьцуулсан хэл шинжлэлийн чухал эх сурвалж болж, хэл шинжлэлийн ухааны хүрээ царааг тэлж, тусгай хэлнүүдийн түгээмэл шинжийг болон өвөрмөц байдлыг дэлгэн харуулах бололцоо олгодог. (Орчуулах эрдэм, 1976:14)

Орчуулгын онолч, шүлэг судлаач нар өргөлтгүй шүлгийг өргөлттэй болгох гэж үйлээ үзэж, монгол шүлгээ европ хэлний прокрустын оронд тааруулах гэж тамаа цайж байсанд орвол монгол шүлгийн айзам үүсгэдэг, үеийн тоог тэнцүүлэх, улмаар толгой холбох, сүүл холбох, авиа ижилсүүлэх, эн зэрэгцүүлэх, хөгжмийг буулгах, өгүүлбэр зүйн уран маягийг гаргах гээд өдий төдий аргыг судалж, орчуулагчид нь энэ л аргаар шүлгээ орчуулж байвал монголын яруу найраг гадаадын сайхан сайхан шүлэг найргаар баяжихсан даа. (Мэнд-Ооёо Г. “Яруу найргийн орчуулгын түлхүүр” - “Монгол шүлгийн айзам үүсгүүрийг орчуулгын онолын үүднээс тодорхойлох оролдлого” Аким Го, 2006:76)

Яруу найргийн орчуулга хийхэд орчуулагчийн бүх авьяас билэг, мэдлэг, чадвар онцгой шаардлагатай юм. Тухайлбал, “Сэтгэл судлалын шинжлэх ухаан бол хүний хэл сэтгэхүй зайлшгүй холбоотой гэдгийг нотолдог. Хүн зөв ойлголтоос, зөв бодомжид хүрч, зөв бодомжуудаас зөв дүгнэлт гаргадаг. Зөв дүгнэлт гэдэг нь зөв танихуй бөгөөд энэ нь хэлэхүйд хүргэнэ.” (Бямбаа Б, 2006:14)

“Бүтээлч орчуулга үндэсний соёлыг баяжуулаад зогсохгүй заримдаа үндэсний утга зохиол бүтээлүүдээс ялгарахгүй болох тал ч бий. Тухайлбал, А.С. Пушкины “Алтан загас”- ны үлгэрийг эрдэмтэн зохиолч Ц.Дамдинсүрэн орчуулсан нь монгол шүлэг мэт монголчуудын сэтгэлд хоногшиж үеийн үед уншиж, ярьсаар иржээ.

Энэхүү шүлгийг / “Сказка о рыбаке и рыбке” / 1938 үүнд орчуулсан байна. Тэрээр хэлэхдээ - Шүлэг болоод үргэлжилсэн үгийн зохиол орчуулах нь өөр өөр юм. Үргэлжилсэн үгийн зохиолыг орчуулахад гол төлөв утгыг нь чухал болгоно. Гэтэл шүлэг бол тийм биш шүлгийг зохиох ба засахад утгаас нь гадна бас шүлгийн хэмжээ, уншигдах аялгууг чухал болгоно.” гэжээ. (Мандах Д, 2008:4)

Хэл бичгийн ухааны доктор Б.Магсаржав хэлэхдээ: - Гадаад хэлнээс шүлэг орчуулахад хэдэн зүйл мөрдлөг байна уу гэж боддог. Үүнд -

- Утгыг ухаж олох
- Утгыг олохын тулд аялгууг мэдрэх
- Аялгууг буулгахын тулд үгийг онож сонгох
- Үгийг сонгохдоо шүлгийнхээ хэмжээ, хэмнэлд тохируулах
- Хэмжээ хэмнэлийг тохируулахын тулд гадаадын шүлгийн холбоцыг монгол шүлгийн холбоцоор буулгах.

Тэгэхлээр яруу найраг бол сэтгэлийн илэрхийлэл, яруу найргийн орчуулга бол гадаад хүний сэтгэлийн илэрхийллийг монгол хүний сэтгэлд нэвтрүүлэхдээ үг, өгүүлбэр, тэдгээрийн цогцыг хүлээн авч байгаа хүний сэтгэлд гүн нийцэхүйц аргыг олох хэрэгтэй юм. (Утга зохиолын орчуулгын хэл найруулга, 2010:48)

Орчуулгын хэл шинжлэлийн онол нь хоёр хэлний үгсийн бүрэлдэхүүн, хэл зүйн байгуулал, найруулга зүйн онцлогийг харьцуулж, орчуулгын практикийг

задлан шинжилдэг утга зохиол судлал орчуулгын гоо зүйн талыг голлон анхаардаг байна. Орчуулгад сэтгэхүйн зүйн үүднээс хандана гэдэг бол орчуулга хийх үйлдлийн сэтгэхүйн процессыг судална гэсэн үг. Харилцааны онол орчуулагчийн тусламжтайгаар мэдээлэл дамжуулах онцлогийг судалж байна. Ер нь орчуулгыг аль ч талаас нь судаллаа гэсэн эх, орчуулга хоёр дүйж байна уу, үгүй юү гэдгийг авч үздэгийг онцлон тэмдэглэвэл зохино.

Үүнийг доорх хэдэн баримтлалаас тодорхой харж болно.

- Хэлбэрийг тохируулах үзэл баримтлал - Энэ нь эх зохиолын агуулгыг харгалзахгүйгээр хэлбэрийг нь буулгана, өөрөөр хэлбэл эх хэлнийхээ үг найруулах ёсыг баримтлалгүй, гадаад хэлний үг үсэгт баригдан махчилж орчуулна гэсэн үг.
- Хэм хэмжээ – агуулгыг тохируулах үзэл баримтлал - Энэ нь дээрх үзэл баримтлалын эсрэг гарч ирсэн чиглэл юм. Энэ үзлийг баримталдаг орчуулагчид нь гадаад хэлээр байгаа агуулгын бүхий л чухал элементийг буулгах эх хэлнийхээ хэм хэмжээг харгалзах зэрэг гэсэн хоёр шаардлагыг биелүүлэх гэж эрмэлзэж байсан байна.
- Төгөлдөр орчуулгын тухай үзэл баримтлал - Төгөлдөр орчуулгын ялгарах онцлог нь эх бичгийн агуулгыг бүрэн гаргах, агуулгыг гаргахдаа эх хэлний хэрэглүүртэй яг таарах хэрэглүүр ашиглах явдал мөн. Яг таарах хэрэглүүр гэдэг нь бүтцийн хувьд төсөөтэй байхыг бус, харин үүргийн хувьд дүйж байхыг хэлнэ.

Үүргийн хувьд дүйлгэх үзэл баримтлал - Орчуулга дүйж байна уу үгүй юү гэдгийг ихэвчлэн эх, орчуулга хоёрыг харьцуулж баймааж нь тогтоодог. Тэгвэл энэ үзлийг баримтлагчид нь орчуулгыг уншигч, эх бичгийг уншигч хоёрын сэтгэгдлийг харьцуулахыг санал болгож байна. (Аким Г, 1984:10)

“... Бичиг зохиолыг хөрвүүлэхдээ нүд хэдий гадаад бичгийг үзэвч утгыг найруулан хөрвүүлэхэд нэг эгшин хэмээн монгол үгийн ёс зүйгээс ангижрахгүй байх” зарчмыг Ринчен гүүш өөрөө томьёолон орчуулах үйлдээ ягштал баримталснаар түүний орчуулгыг уншихад гадаадын зохиолчийн зохиолын эрдэнийн утгыг зүрх догдлон танихын зэрэгцээгээр монгол хэлнийхээ яндашгүй далайд дураар сэлж, гүнд нь өнгө бүрээр солонгорох үгийн нь сувдын тансгийг сэтгэлээрээ мэдэрч байдаг билээ. (Адьяа О, 2008:62)

Өмнөх зууны хоёрдугаар хагасаас японы зохиол бүтээл орчуулах болсон ба ялангуяа яруу найраг зонхилж байсан юм. Японы яруу найргийн нэгэн төрөл болох хайкү шүлгийг хагас зуун жилийн тэртээгээс монгол хэлнээ буулгаснаар хайкүг сонирхон судлах, зохиох нь элбэгшсэн юм. 1960–аад оны эхээр нэрт яруу найрагч Б.Явуухулан японы хайкү шүлгийн гол төлөөлөгч Мацүо Башёогийн шүлгийг монгол хэлнээ орчуулсан ба түүнээс хойш Ж.Лхагва, Д.Одонхорлоо нар хайкү шүлгийг монгол хэлнээ орчуулснаар монголын утга зохиолд үнэтэй хувь нэмэр оруулсан. Анх хайкү шүлгийг орос хэлнээс орчуулж байсан бол сүүлийн үед эх хэлнээс нь буюу япон хэлнээс орчуулах явдал ихэсжээ.

Хайкү шүлгийн бүтэц, киго, кирэжи

Монголчууд шүлгийнхээ арга маяг, хэв загвар, нэр томъёог түүхийн явцад, энэтхэг төвдийн яруу найруулгын онол, барилаар баяжуулж иржээ. Харин япончууд хятадын ханз үсгийн нөлөөгөөр шүлэг дуугаа ханзаар бичин утгыг илэрхийлдэг байна.

Хайкү шүлэг байгалийн үзэсгэлэн гоо, хүний сэтгэлийн өнгө аясыг хослуулан илэрхийлдэг, үеийн шүлэг юм. Түүнчлэн хайкү шүлгийг гүн ухааны шүлэг гэж тодорхойлдог. Өөрөөр хэлбэл далд утга агуулсан өгүүлэмж бүхий зохион бичих маяг, зохиолч шүлэг бүтээхдээ гол утгыг нууж, өгүүлэмжээ зориудаар өөр хэлбэрт шилжүүлэн урлахдаа үндсэн утгыг илэрхийлэн бодож нээхийг шаардсан зохиолууд ерөнхийдөө далд өгүүлэхүйн аргаар бүтдэг байна.

Хайкү нь вакагийн дээд 5-7-5 болоод доод мөр 7-7 гэх олноороо зохиодог рэнкагийн дээд хэсгийг нь авч Эдогийн үед яруу найрагч Мацүо Башёо хайкай шүлэг гэж үүсгэн бие даасан төрөл болгон нийтэд түгээжээ. Хайкай гэх нэрийг Эдогийн үед хэрэглэдэг байжээ. Хайкай шүлэг гэх оноосон нэрний кай –г нь хасаад шүлэг буюу кү- г залган хайкү болгосон нь одоогоос 100 гаруй жилийн өмнө Масаока Шикигийн хүрээний найрагчид юм.

Японы шүлэг хэд хэдэн төрөл байдаг ба түүний дотроос хайкү нь 5-7-5 гэх 17 үетэй 3 мөрт шүлэг юм.

Хайкү шүлэг нь дараах гурван онцлог шинжтэй.

1. Дээд мөр 5 үетэй, дунд мөр 7 үетэй, доод мөр 5 үетэй байдаг.
2. Хайкү шүлэгт киго 季語 буюу улирал илэрхийлсэн бэлгэдэл үг байдаг. Уг бэлгэдэл үгээр тухайн хайкүг илэрхийлсэн улирлыг хялбархан мэдэх боломжтой.
3. Хайкүд кирэжи 切れ字 нь багадаа нэг орсон байдаг. Кирэжиг махчилан орчуулвал таслах үсэг гэх ба кирэжи бичигдсэн мөрөөр таслал болгон, ард орсон мөрийг тодотгож өгдөг. Хайкү шүлэгт や、かな、けり、なり、ぞ、がも、もがな、らん、し、か、よ、せ、や、つ、れ、ぬ、ず、に、へ、け、じ гэх мэт кирэжи байдаг бөгөөд ихэвчлэн や、かな、けり нь хэрэглэгддэг.

Киго буюу улирал илэрхийлсэн бэлгэдэл үгтэй хайкүг тогтсон загвартай хайкү гэж нэрлэдэг бол мөн тогтсон загвараас гажсан хайкү зохиогддог. Түүнийг чөлөөт арга барилтай хайкү, тогтсон загваргүй улирлын бэлгэдэл үггүй хайкү гэж нэрлэдэг байна.

Тухайлбал,

1. Озаки Хоүсай шүлэгчийн дараах хайкү шүлгүүд нь чөлөөт арга барилаар зохиогдсон юм. (太田揺子, 平成 30 年:7)

Япон эх	Монгол галиг	Монгол орчуулга
い な 入れものが無い	и-рэ-мо-но га на-и (7)	Хийх сав байхгүй
りょうて 両手で	рио-ү-тэ-дэ (4)	Хоёр гартаа
う 受ける	ү-кэ-рү (3)	Авах

Япон эх	Монгол галиг	Монгол орчуулга
こんなよい	ко-н-на ё-и (5)	Ийм сайхан
ひとり つきを一人で	цү-ки о хи-то-ри-дэ (7)	Сарыг ганцаараа
み ね 見て寝る	ми-тэ нэ-рү (4)	Хараад унтана

Энэ мэт хайкү шүлгийн тогтсон загварыг баримтлаагүй зохиогдсон алдартай хайкү шүлэг олон бий.

Хайкү шүлэгт киго буюу улирал илэрхийлсэн бэлгэдэл үг ганцаас илүү орсон байх тохиолдолд байдаг. Хэрэв нэг улирлыг илэрхийлж буй хоёр ба түүнээс дээш киго орсон хайкүг улирал давхцуулсан хайкү гэж нэрлэдэг бол нэг хайкүд улирал илэрхийлсэн бэлгэдэл үг хэд хэд орсон бол түүнийг улирал өөр гэж нэрлэдэг байна.

Тухайлбал,

2. Ямагүчи Содоү шүлэгчийн дараах хайкү шүлэг нь улирал давхцуулан зохиогдсон. (太田揺子, 平成 30 年:8)

Япон эх	Бэлгэдэл үгийн тайлбар	Монгол галиг	Монгол орчуулга
め あおば 目に青葉	<u>Ногоон навч нь зуны улирыг илэрхийлсэн бэлгэдэл үг</u>	мэ-ни а-о-ба	Нүдэнд ногоон навч
やま 山ほととぎす	<u>Хөхөө шувуугаар зуны улирлыг илэрхийлсэн бэлгэдэл үг</u>	я-ма хо-то-то-ги-сү	Ууланд хөхөө шувуу
はつがとお 初鰈	<u>Толбот жад загас нь мод ногоорох цагаар өмнө зүгийн далайгаас ирдэг байсан учир түүнийг анхны толбот жад загас гэж нэрлэн зуны улирлыг бэлгэддэг болсон байна.</u>	ха-цү ка-цү-о	Анхны толбот жад загас

3. Кобаяши Исса шүлэгчийн дараах хайкү шүлэгт хоёр өөр бэлгэдэл үг орсон байна. (太田揺子, 平成 30 年:9)

Япон эх	Бэлгэдэл үгийн тайлбар	Монгол галиг	Монгол орчуулга
ねこ こ 猫の子が	Муурын зулзага хаврын улирлыг илэрхийлсэн бэлгэдэл үг.	нэ-ко но ко га	Муурын зулзагын
て 手でおとすなり	-	тэ-дэ о-то-сү-на-ри	Гараараа унагаах
みみ ゆき 耳の雪	Цас бол өвлийн улирлыг илэрхийлсэн бэлгэдэл үг.	ми-ми но ю-ки	Чихний цас

Хайкү шүлэгт хоёр өөр бэлгэдэл үг орсон хайкү шүлгийг аль улирал нь илүү тодотгон илэрхийлж байгаа нь тухайн хайкү шүлгийн бэлгэдэл үг болдог. Дээрх хайкү шүлгийн хувьд “Муурын зулзага”-аас илүүтэйгээр “Цас” гэсэн үг нь илүү хүчтэй өвлийн улирлыг илэрхийлж байгаа учир энэ шүлгийн бэлгэдэл үг болно гэж бодож байна.

Монгол шүлэг ба монгол яруу найрагч, эрдэмтэд хайкү шүлгийн тухай

Улс үндэстэн бүрийн хөгжим аялгуу нь байгаль орчин, аж амьдрал, ахуй нөхцөлийн өвөрмөц байдал, зэргээс шалтгаалан өөр өөрийн онцлог намба төрхтэй байх нь мэдээж хэрэг юм.

Монгол шүлгийг хармагц эсвэл сонсмогц таних тэмдэг нь “толгой холболт” юм. (Л.Түдэв, 2002:389) Монгол шүлгийг тусгайлан үеэр бичдэггүй ч үеэр бичиж болох юм. XIV зууны яруу найрагч эрдэмтэн Чойжи-Одсэр шүлэгтээ аажим давшуулан тааруулах арга хэрэглэсэн байна.

- Дөрвөн гартай нигэн нигуртан (9)
- Дүгүриг улаган гурван нидүтэй (10)
- Төрүлки ургусан шира үсүтэй (11)
- Түгэл күмүүн- н жагугсан араг-а- тай (12)

Хэрэв 9 үеийн дараа шууд 12 үе орвол шүлгийн хэмжээ доголдох учиртай. Аажмаар ахиулж байгаа нь шүлгийн хэмжээнд төдийлөн өөрчлөлт орсонгүй. (Монгол шүлгийн онцлог түүхийн зарим асуудал, 1977:76)

Монгол шүлгийн үеийн тоо дунджаар 5 – 15 орчим байхад аман зохиол ерөөл магтаал, тууль зэргийн шүлэг голдуу 6, 7, 8 гэсэн тоо ихэвчлэн тохиолдоно.

Монгол шүлгийн тогтолцооны талаар гэвэл ардын аман яруу найраг хийгээд дундад эртний бичгийн шүлгийн үндсэн хэрэглэгдэхүүнд хийсэн ажиглалт судалгаанаас үзвэл үеийн тоог тэгшитгэх зарчмыг баримталдаг хэмнэлтэй дүйцүүлэн үзэж болмоор байгаа юм. Гэхдээ монгол шүлгийн үеийн тоог тэнцүүлэх зарчим нь долоон үет, арван нэгэн үет гэхчлэн яг таг хатуу тогтоох аргагүй бөгөөд нэлээд чөлөөтэй гүйлгэн байдаг нь монгол хэлний байгууллын онцлогоос гадна холбоцын олон арга, эн зэрэгцүүлэх ёс, цэглэлт мөр тэргүүтэн ч чухал нөлөөтэй байдаг.

Монголчууд хайкү шүлгийг мэддэг болсноос хайкү шүлгийг өөр өөрсдийн байр сууринаас тайлбарлан, орчуулж, зохиох болсон нь манай уран зохиолыг өргөжих нэгэн үндэс болж байна.

Б.Явуухулан - “Хайкү шүлэг эгзэгийн шүлэг учраас түүнийг ойлгохын тулд өгүүлэгдэж байгаа үзэгдэл, юмсын мөн чанар, орчин тойрных нь холбогдол зэргийг сайн мэддэг байх ёстой” гэжээ. Хайкүг бичихэд гойд чамин хэллэг, гоц ондоо зүйрлэл шаардлагагүй, харин ямар нэгэн үзэгдэл юмсын нэгээхэн эгзэгтэй өчүүхэн хэсэг мөртлөө, тэрхүү үзэгдэл юмсынхаа хөрөг зургийг төлөөлөн гаргаж чадахуйц, мөнөөхөн эгзэгийг олж энгийн үгээр зурагладаг байна. Тэрхүү өчүүхэн зураглал нь үзэгдэл юмсын бүхэл бүтэн дүр зургийг нүдээр үзэж, биеэр мэдрэх адил хүний сэтгэл санаанд буулгадаг ажээ.

Нэрт зохиолч Б. Явуухулан дөрвөн улирлыг хайкү шүлгээр илэрхийлсэн байдаг.

1. Хавар

Хашаа бууцны хөлөөр
Хар турлиах сүрэглэн ирж
Хөлдүүс ховхлон гүйлдэнэ

2. Зун

Амаа өдөржин ангайж
Атан тэмээ нүцгэн биендээ
Хүйт мөрөөдөн зогсоно

3. Намар

Бургаст голын тохойн
Буруу эргэсэн цөөрөм дээр
Өнчин шар навч эргэлдэнэ

4. Өвөл

Өвөр нөмөрт бараантах
Өвөлжөө бууцны хөл өөд
Малын жим яарна. (Б.Явуухулан, 1985:293)

Нэрт найрагчийн зохиосон хайкү шүлэгт хөлдүүс, тэмээ нүцгэн биендээ, шар навч, өвөлжөө зэрэг киго буюу улирал илэрхийлсэн бэлгэдэл үг оновчтой тусгагдсан байна.

Япончууд суурьшмал соёл иргэншилтэй, газар тариалан эрхэлдэг бол монголчууд нүүдэлчин соёл иргэншилтэй, мал аж ахуй эрхэлдэг. Амьдралын хэв маягаараа ялгаатай боловч улирлын хувьд адилхан дөрвөн улиралтай. Үүгээрээ киго буюу улирал илэрхийлсэн бэлгэдэл үгийг ашиглан хайкү зохиох боломжтой нь харагдаж байна.

Ж.Лхагва - “Арван долоон үенд
Алтан дэлхийг багтаах нь
Алгын чинээ хайкү аж”

Д. Одонхорлоо - Хокку буюу Хайку (тансаг шат) гурван мөрт, Танка (богино дуу) таван мөрт хоёр урсгалаар хөгжлийнхөө үе шатыг өвлөн дамжиж Ази төдийгүй Өрнөдийн оронд дэлгэрсэн богино шүлгийн энэ сонгодог хэлбэр манай монголын тал нутагт сакура –тай хамт цэцэглэх цаг нэгэнт иржээ .

Монголын үндэсний зан үйл, сэтгэлгээний өвөрмөц онцлогийг тусгадаг “Ертөнцийн гурав” гэдэг богино шүлэг нь зөвхөн уран үгээр бус дүрийг уран санаагаар илэрхийлэх, ертөнцийн үзэгдлийг гүн ухааны бясалгалаар тайлах зэрэг сонгодог шинжээрээ японы Хайку – тай төстэй ажгуу.

Б.Нарандэлгэр - “Япон хайкү шүлгийн онцлог, монгол гуравт шүлэгтэй харьцуулах нь” сэдэвт хэл бичгийн ухааны магистрын зэрэг горилсон зохиолдоо “Хайкү нь японы үндэстний уламжлалт зан заншил, гүн ухаан, гоо зүйн

ойлголттой нягт холбогдож утга санаа нь байгаль, улирлын байдалтай бэлгэдэлт үсгээр утга санаа нь тайлагдана” гэжээ.

Утга зохиол судлаач Д.Цэдэв - “Уламжлалт хайкү бол бясалгал эргэцүүллийн охь ханд, байгаль хүний харилцааны торгон агшин, япон хэлний 5 – 7 – 5 үеэр бүтдэг шүлэг мөн.”

Т.Галсан - “Агуу их далайн дундах өчүүхэн арлыг үзээд, уйлах загасны нулимс гашуун гэх мэт соцоодог сэрэл сэхээрлийн шүлэг юм.”

Л.Дашням - “Японы хайкү танкаг дуурайн шүлэг бичих оролдлого хийж байснаа дурсан, нэг юмнаас нөгөөг олж харах юм уу, ухаарах нь оюуны гайхамшигтай сайхан соёл доо” хэмээн өгүүлсэн байна.

Монгол яруу найрагч, эрдэмтдийн хайкү шүлгийн орчуулга

Монголын зохиолч эрдэмтдийн Мацүо Башёогийн алдарт хоёр хайкү шүлгийг монгол хэлнээ хэрхэн орчуулан буулгасныг ажиглаж үзье.

1. 古池^{ふるいけ}や^{かわず}蛙^と飛^こび^{みず}込^{おと}む水の音

кирэжи хаврын улирлыг илэрхийлсэн киго буюу бэлгэдэл үг

Япон эх	Монгол галиг	Монгол орчуулга	Англи орчуулга (R.H. Blyth, 1981:246)
ふるいけ 古池や	хү-рү-и-кэ яа (5)	Хуучин цөөрөм	The old pond;
かわずと 蛙飛び込 む	ка-ва-зү то-би-ко-му (7)	Мэлхий үсрэн орох	A frog jumps in,
みずおと 水の音	ми-зү но о-то (5)	Усны чимээ	The sound of the water

“Хаврын өдөр” хайкүг мөр бүрээр дээрх япон, англи хэлнээс махчлан орчуулвал:

Япон эх	Япон хэлнээс	Англи хэлнээс
ふるいけ 古池や	Хуучин цөөрөм や бол кирэжи	Хуучин цөөрөм
かわずと 蛙飛び込 む	Мэлхий үсэрч орох	Нэг мэлхий дотогшоо үсрэх
みずおと 水の音	Усны дуу, чимээ	Усны дуу чимээ

Орчуулга 1

Б.Явуухулан (орос хэлнээс)

Хуучин цөөрөм уруу
Хөөрхий мэлхий дэвхрэхэд
Усны чимээ гарав.

Орчуулга 2

Т.Аюурзана (орос, англи хэлнээс)

а) Хуучин цөөрөм
Мэлхий үсэрч
Ус намжлаа

- b) Хөгшин цөөрөм
Усанд мэлхий үсэрлээ
Аниргүйн дунд цүлхийв
- с) Эртний цөөрөм
Мэлхий үсрэв
Усны чимээ

Орчуулга 3

Т.Болдбаатар (япон хэлнээс)
Хуучин цөөрөм
Мэлхий үсрэн орох
Усны чимээ

2. ^か枯^{えだ}れ^{からす}枝に鳥のとまり^{あき}けり^く秋の暮れ

өвлийн улирлыг илэрхийлсэн киго буюу бэлгэдэл үг → кирэжи

Япон эх	Монгол галиг	Монгол орчуулга	Англи орчуулга (R.H. Blyth, 1981:330)
^か 枯 ^{えだ} れ ^{からす} 枝に	ка-рэ э-да-ни (5)	Нүцгэн мөчир дээр	On a withered branch
^{からす} 鳥のとまりけり	ка-ра-сү но то-ма-ри-кэ-ри (7)	Хэрээ сууна	A crow is perched
^{あき} 秋の ^く 暮れ	а-ки но кү-рэ (5)	Намрын үдэш	An autumn evening

“Нүцгэн мөчир” хайкүг мөр бүрээр дээрх япон, англи хэлнээс махчлан орчуулвал:

Япон эх	Япон хэлнээс	Англи хэлнээс
^か 枯 ^{えだ} れ ^{からす} 枝に	Навч нь хагдран унасан мөчир дээр	Хувхайрсан, хатсан мөчир дээр
^{からす} 鳥のとまりけり	Хэрээ суух ке ^り бол кирэжи	Нэг хэрээ амарна, сууна
^{あき} 秋の ^く 暮れ	Намрын харуй бүрий, бүрэнхий үе	Намрын үдэш

Орчуулга 1

Б.Явуухулан (орос хэлнээс)
Нүцгэн мөчир дээр
Навсар хэрээ сууж байгаа нь
Намрын үдэш санж

Орчуулга 2

Ж.Лхагва (орос хэлнээс)
Хоосон цулгуй мөчир дээр
Хон хэрээ суух нь
Намрын орой санж

Орчуулга 3

Д.Цэдэв (япон хэлнээс)

Хувхай мөчир дээр
Хар хэрээ сууж
Намрын орой санж

Орчуулга 4

Г.Аюурзана (орос, англи хэлнээс)

Нүцгэн мөчир дээр
Ганц хэрээ сууна...
Намрын үдэш.

Мацүо Башёогийн “Хуучин цөөрөм ” гэх хайкүг 3 орчуулагч 5 янзаар орчуулжээ.

“Хуучин (古)” гэхийг Б.Явуухулан, Г.Аюурзана (а), Т.Болдбаатар нар “Хуучин” хэмээн орчуулж, Г.Аюурзана (b), (c) –д “Эртний”, “ Хөгшин” гэж орчуулсан байна. Эдгээр нь утга санааны хувьд ойролцоо утгатай ч үнэлэмж, цаад санаа, цаг хугацааны хувьд ялгаатай юм.

“Мэлхий үсрэн орох” гэхийг Б.Явуухулан “Хөөрхий мэлхий дэвхрэхэд”, Г.Аюурзана “Мэлхий үсэрч”, “Усанд мэлхий үсэрлээ”, “Мэлхий үсрэв”, Т.Болдбаатар “Мэлхий үсрэн орох” гэж орчуулжээ. Эх хэлнээс харахад мэлхий - 蛙 (кавазү), нисэх, хөөрөх - 飛 び(тоби), дотогш нэвтрэн орох - 込 む(комү) гэсэн санаа бөгөөд 飛 び 込 む (тобикомү) гэж нийлүүлж хэрэглэхэд ямар нэгэн зүйлийн гүнрүү, дотогш үсрэн орох гэсэн санааг илтгэнэ.

“Усны чимээ” гэхийг Б.Явуухулан “Улсны чимээ гарав”, Г.Аюурзана (а)“Ус намжлаа”, (b) “Аниргүйн дунд цүлхийв”, (c) “Усны чимээ” Т.Болдбаатар “Усны чимээ” хэмээн хөрвүүлсэн байна. Ус - 水 (мизү), の-ны, ийн (монгол хэлний харьяалахын тийн ялгалтай утга дүйнэ), дуу чэмээ, чимээ - おと 音 (ото) гэсэн утгатай .

Мацүо Башёогийн “Нүцгэн мөчир” хайкүг 4 орчуулагч өөр өөр янзаар орчуулсан байна.

“Нүцгэн мөчир дээр” гэхийг Б.Явуухулан “Нүцгэн мөчир дээр”, Ж.Лхагва “Хоосон цулгуй мөчир дээр”, Д.Цэдэв “Хувхай мөчир дээр”, Г.Аюурзана “Нүцгэн мөчир дээр” хэмээн орчуулжээ. Нүцгэн мөчир - 枯 れ 枝 へ (карэ эдани) - 枯 れ (карэ) - хоосон, үгүй болох, 枝 (эда) - мөчир, салаа, гишүү, へ—д, -т (өгөх оршихын тийн ялгал) монголчууд бид энэ үгийг ойлгохдоо намрын сүүл сар навч нь хагдран унасан модны мөчир, хаврын эхэн сар болон цас ороогүй үеийн модны мөчир зэргээр төсөөлөн гурван ч улирлыг дүрсэлж болох юм. Гэвч хайкү шүлэгт 枯 れ (карэ) нь өвөл цагийг илэрхийлдэг киго буюу улирал илэрхийлсэн бэлгэдэл үг ажээ.

“Хэрээ суух нь” гэхийг Б.Явуухулан “Навсгар хэрээ сууж байгаа нь”, Ж.Лхагва “Хон хэрээ суух нь”, Д.Цэдэв “Хар хэрээ сууж”, Г.Аюурзана “Ганц хэрээ сууна...” хэмээн орчуулсан байна. Орчуулгаас харахад орчуулагч нар хэрээний үнэлэмжийг тусгаж өгсөн байна. Хэрээ - 鳥^{からす} (карасү), の (но) -ийн, -ны (харьяалахын тийн ялгал), зогсох - とまり (томари), けり (кэри) нь өмнө орсон мөрийг төгсгөх үед (вака болоод хайкү шүлэгт хэрэглэгдэх нь элбэг) хэрэглэдэг.

Эх хэл дээрх хайкүг үзэхэд хэрээний талаарх үнэлэмжийг тусгаагүй байна. Зохиогч навч нь хагдран унасан мөчир дээр ганц хэрээ суун, намар орой сэрүү орсон цагийн нар жаргасан бүрэнхий үеийг дүрслэн байгааг нь уншихад ганцаардал, гуниг мэдрэгдэж байгаа юм.

Намрын үдэш гэхийг Б.Явуухулан “Намрын үдэш санж”, Ж.Лхагва “Намрын орой санж”, Д.Цэдэв “Намрын орой санж”, Г.Аюурзана “Намрын үдэш” гэж орчуулжээ. Намар – 秋^{あき} (аки), の (но) -ийн, -ны (харьяалахын тийн ялгал), 暮^く 々 (күрэ) - үдэш (нар жаргахаас цагаан гэгээ тасрах хүртэл хугацааг хэлнэ) гэх утгатай юм.

Орчуулагч эх зохиолын тэрхүү айзам нугалаа, уянгалаг аясыг олж таниагүй, гаргаж чадаагүй бол, зүйрлэн хэлэхэд, лимбийн яруухан эгшиг хөрөөний хяхтнсан дуугаар солигдох адил болно. Ялангуяа эх зохиолын байгалийн зураглал, баатруудын сэтгэлийн хөдлөл, хайр дурлалын тухай хүүрнэл тэр аяараа уянга байдаг. Яруу найргийн орчуулга нь орчуулгын үйл ажиллагааны нэн хүнд нэг салбар юм. Учир нь хэл хэлний зүй тогтол уялдаж шүлэглэх ёс журам өөр өөр байдгийн дээр шүлгийн утга агуулга, үзэл санааг төдийгүй хөг айдм, зохиомж бүтцийн талыг буулгах шаардлагатай байдаг. Иймээс авьяас билигтэй, хашир туршлагатай орчуулагч нар шүлгийг орчуулахдаа үгийг хэрхэн сонгож, уран сайхныг нь яаж буулгаж, өөрөөр хэлбэл ямар арга зарчим хэрэглэж вэ гэдгийг үзэхэд сонин билээ. Шүлэг орчуулахад үг бүрийг санасны зоргоор чөлөөтэй хэрэглэх боломж бага байдгийн улмаас орчуулгад үгийг дүйх үгээр нь оноож тавих чадвар маш чухал байдаг байна. Мөн шүлэглэх ёс журмын дагуу үгийг яг дүйлгэн буулгаж болохгүй үе гардаг. Ийм үед үгийн утгыг уул эхтэй нь харьцуулахад ялихгүй бууруулах буюу хүч оруулах, өөрөөр хэлбэл үгсийн сангийн хувиргалд оруулахаас өөр аргагүйд хүрдэг. Үүнийг үгсийн сангийн утгаараа заримдаг тохирсон үг гэж нэрлэдэг. (Аким Г, 1984:90)

Мөн танихуйн яруу найргийн зүйрлэлд найрагчийн сэтгэн бодох, дүр бүтээх, уншигчийн уг дүрийг танихын тулд сэтгэн бодох чадвар чухал. Тиймээс яруу найрагчийн шүлэг найраг нь тэрээр ертөнцийг үзэх үзлийг мөн л өөрийнхөөрөө ухааран ойлгож авч буй бөгөөд өөр нэгэн огт өөрөөр ухаарч хүлээж авахыг огтхон ч үгүйсгэх аргагүй юм. Найрагчийн ертөнц түүний шүлгийн хэлээр илэрч байгаа бол уншигч энэ ертөнцийг хэрхэн хүлээж авч ойлгож байгаа нь мөн л түүний танихуйн туршлага, дотоод ертөнцөөс хамаарна.

Шүлэг яруу найраг зөвхөн мэдээлэл дамжуулаад зогсохгүй, найрагчийн бодол санаан дахь ертөнцийн түмэн зүйлийн холбоо хэлхээг шинэ дүрд амилуулж,

юм үзэгдэл ухагдахууныг цоо шинээр харж шинэ дүр, дүрслэл бүтээдэг. (Долгор С, Нансалмаа Н, 2014:155)

Дүгнэлт

Яруу найргийн орчуулга тухайн орчуулагч хүний аливаа зүйлийг танин мэдсэн туршлага, юмс үзэгдлийг өөртөө тусган авах хувь хүний онцлог зэрэгтэй шууд холбоотой нь харагдаж байна.

Хоёр өөр соёлын аль нь илүү оновчтой оновчгүй гэх мэтээр хэлэлцвэл тун учиргүй зүйл болно. Гагцхүү тухайн соёл хэлтний уламжлалт аж төрөх ёс, зан заншил, ертөнцийг таньсан байдал, ертөнцийг үзэх үзэл түүнийг үнэлэхдээ ямар зүйлийг тогтсон хэмжүүр болгож айлчилж ангилдгийн өвөрмөц онцлог нь хэлнийхээ адилтгал, зүйрлэлд тодорхой туссан байдгийг дээрх орчуулгаас харж болмоор.

Хайкү шүлэгт далд утга санаа агуулсан зүйрлэлийн бэлгэдэл үгийг оруулж өгөх нь чухал байдаг байна. Үүнийг сайн мэдэхгүй бол хайкүг орчуулах нь учир дутагдалтай гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл тухайн бэлгэдэл үгийн тусламжтайгаар цөөхөн хэдэн үгэнд багтааж бүхэл бүтэн агуулгыг илэрхийлдэг. Энэхүү бэлгэдэл үг нь байгаль, цаг уур, тухайн агшныг илэрхийлээд зогсохгүй японы соёл, ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний онцлог гүн шингээстэй байдаг тул эх хэлнээс нь орчуулсан орчуулга илүү оновчтой нь ажиглагдлаа.

Хайкү шүлэг хэдийгээр гүн ухааны өнгө аястай боловч сонсож буй хийгээд орчуулж буй хүний сэтгэлгээний онцлог, ертөнцийг үзэх үзэл танин мэдрэх хувь хүнтэй шууд холбоотой тул орчуулгын олон хувилбар байж болох талтай. Хэдийгээр Хайкү нь гүн ухааны шүлэг гэгддэг боловч дэлхийн ихэнх хэлнээ орчуулагдан гарсан нэг онцлогийг Киго буюу Бэлгэдэл үгийн тайлбар толь бичгийн ач хэмээн олон эрдэмтэд онцлон тэмдэглэсэн байдаг.

Хэлний хувьд ч монгол япон хэл ч адил төст тал олон. Иймээс яруу найргаараа дамжуулан илэрхийлэх энэ хоёр ард түмний сэтгэлгээнд ч адил төст зүйл цөөнгүй байгаа юм биш байгаа.

Ном зүй

- 1) Адьяа О. (2008), Орчуулга: Онол, туршлага, сургамж, УБ.
- 2) Аким Г. (1984), Орчуулгын санг уудлахад, УБ.
- 3) Аюурзана Г. (2002), Дурлалгүй ертөнцийн блюз, УБ.
- 4) Гаадамба Ш. (1989), Утга зохиолын үндэс, УБ.
- 5) Гүрбазар Р. (1996), Орчуулгын онол, дадлагын үндэс, УБ.
- 6) Дулам С. (1977), Дундад эртний дорно дахины уран зохиолын тойм, УБ.
- 7) Дэмбэрэл С. (2010), Япон монгол толь бичиг, УБ.
- 8) Комиссаров В.Н. (2008), Орчуулгын онол, УБ.
- 9) Лодой Г. (2002), Философи ба шинжлэх ухааны арга зүй, УБ.
- 10) Лхагва Ж. (1974), Японы яруу найраг, УБ.
- 11) Мандах Д. (2010), Японы сонгодог яруу найргийн орчуулгын асуудалд - Хайкү шүлгийн орчуулгын жишээн дээр, УБ.

- 12) Мандах Д. (2008), Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан судалгааны зарим шинэлэг асуудал, /хэл бичгийн ухааны дэд докторын зэрэг горилсон бүтээл/, УБ.
- 13) Мэнд-Ооёо Г. (2006), “Яруу найргийн орчуулгын түлхүүр” – Аким Го. Монгол шүлгийн айзам үүсгүүрийг орчуулгын онолын үүднээс тодорхойлох оролдлого, УБ.
- 14) Нансалмаа Н, Долгор С. (2014), Танихуйн хэл шинжлэл, УБ.
- 15) Нансалмаа Н. (2011), Хэлшинжлэлийн судалгааны арга зүй, УБ.
- 16) Равдан Э. (2013), Хэрэглээний хэл шинжлэл (хэл сурахуйн онол), УБ.
- 17) Равдан Э. (2005), Орчин цагийн хэл шинжлэл, УБ.
- 18) Ринчен.Б. (1991), Марк твений минь махы нь идэж дээ..!”, УБ.
- 19) Туяа Ж. (2014), Хэл , соёл судлал - Онол болоод дадлагын хичээл, УБ.
- 20) Түдэв Л. (2002), Шүлэглэсэн туульс, УБ.
- 21) Уэллек Р, Уоррен О. (1998), Уран зохиолын онол, УБ.
- 22) Хасбаатар Ц. (1989), Уран зохиолын тэмдэглэл, УБ.
- 23) Хөвсгөл С. (2003), Дорно дахины уран зохиол, УБ.
- 24) Хүрэлбаатар Л. (2005), Дуун утгын яруу зохист, УБ.
- 25) Цэдэв Д. (1976), Орчуулах эрдэм, УБ.
- 26) Явуухулан Б. (1996), Японы хайкү хэмээх сонгодог яруу найргаас, УБ.
- 27) Явуухулан Б. (1985), Түүвэр зохиол, УБ.
- 28) Япон утга зохиолын симпозиум. (2005), УБ.
- 29) Blyth.R.H. (1981). Haiku volume 1” , The Hokuseido Press Tokyo
- 30) 太田 揺子、深層学習による俳句の自動生成.,平成 30 年
- 31) デイリーコンサイス-国語辞典,中型版.,株式会社三省堂.,2010 年
- 32) 俳句への一步 .社団法人俳人協会.,平成 20 年
- 33) 浜島栄一 -常用国語便覧. 株式会社浜島書店.,昭和 61 年